



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/547

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "А" заалт үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үдийн цай хөтөлбөрийн сонгон шалгаруулалт, гэрээний биелэлт, сургууль, дотуур байр, цэцэрлэгт хүнсний бүтээгдэхүүн ханган нийлүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Даваадорж -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга


- Гишүүд: М.Пүрэвхүү- Боловсрол, соёл урлагийн газрын дарга
- О.Дарьжав -Мэргэжлийн хяналтын газрын хүнсний эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч
- Б.Анхбаяр -Боловсрол, соёл урлагийн газрын сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн
- О.Өлзийсайхан -Боловсрол, соёл урлагийн газрын дотуур байр, хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
- К.Бямбажав -Стандарт хэмжилзүйн хэлтсийн бүтээгдэхүүн баталгаажуулалтын шинжээч
  - Сумын Засаг дарга
  - Ерөнхий боловсролын сургуулийн захирал
  - Цэцэрлэгийн эрхлэгч

Нарийн бичгийн дарга: Б.Сайнсанаа - Боловсрол, соёл урлагийн газрын Хими биологийн боловсрол хариуцсан мэргэжилтэн

2."Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль"-ийн хэрэгжилт, бага ангийн сурагчдыг 2021-2022 оны хичээлийн жилээс үдийн хоол үйлчилгээнд хамруулах бэлтгэл ажлыг хангуулж, чанар стандартын

шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр үйлчлэх, эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран суралцагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Даваадорж/-д даалгасугай.

3.Хяналт шалгалт хийсэн ажлын тайланг улирал тутамд аймгийн Засаг даргад танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ

